



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 10/02

Улаанбаатар хот

**「 Баянгол дүүргийн засаг даргын 2017-2020
оны үйл ажиллагааны хөтөлбөрийн
2018 оны биелэлтийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1д, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянгол дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийг хангалттай гэж үзсүгэй.
2. Баянгол дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийг хавсралтаар баталсугай.

ДАРГА  Г.ЭНХБОЛД



1160100433